



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2021 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 6/25

Номгон

Баянхонгор аймгийн сумдын Газрын
төлбөрийн хувь хэмжээг шинэчлэн
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйл 35.1.10, Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ҮI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн хэмжээнд мөрдөгдөх Газрын төлбөрийн хувь хэмжээг тогтооход хэрэглэх итгэлцүүрийн тоон утгыг үнэлгээний бүсчлэл, газрын нэгдмэл сангийн дэлгэрэнгүй ангилал бүрээр тооцож, Баянхонгор сумын Хот тосгон бусад суурин газрын төлбөрийн хувь хэмжээг нэгдүгээр хавсралтаар, Баянхонгор сумаас бусад сумын Хот тосгон бусад суурин газрын төлбөрийн хувь хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших, ашиглах гэрээг шинэчлэх, газрын төлбөрийг ногдуулах, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхсайхан)-д даалгасугай.

3. Энэ тогтоолыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Газрын төлбөрийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж захиргааны хэм хэмжээний актын улсын бүртгэлд шинэчлэн бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Норов)-т даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ



0121047

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны
12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит VI хуралдааны
6/25 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт




**БАЯНХОНГОР СУМЫН ХОТ, ТОСГОН БУСАД СУУРИН
ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ**

Газрын үнэлгээний бүсийн дугаар	Газрын зориулалт	Газрын төлбөрийн			
		Суурь үнэ (сая.төг)	Хувь хэмжээ	га (төг)	м.кв (төг)
1	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	250000000	0.4	1000.000	100
2		200000000	0.4	800.000	80
3		100000000	0.4	400.000	40
4		70000000	0.4	280.000	28
1	Гэр бүлийн хэрэгцээ	60000000	1.0	600.000	60
2		50000000	1.0	500.000	50
3		40000000	1.0	400.000	40
4		20000000	1.0	200.000	20
1	ХАА-н үйлдвэрлэл	150000000	0.4	600.000	60
2		100000000	0.4	400.000	40
3		50000000	0.4	200.000	20
4		30000000	0.4	120.000	12
1	ХАА-аас бусад үйлдвэрлэл	200000000	0.4	800.000	80
2		160000000	0.4	640.000	64
3		80000000	0.4	320.000	32
4		50000000	0.4	200.000	20

оОо

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны
12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит VI хуралдааны
6/25 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



БАЯНХОНГОР СУМААС БУСАД СУМЫН ХОТ, ТОСГОН,
БУСАД СУУРИН ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

№	Газар ашиглах зориулалт	Газрын төлбөрийн			
		Суурь үнэ /сая /	Хувь хэмжээ	га /төг/	м.кв /төг/
1	Худалдаа, бүх төрлийн үйлчилгээ	20000000	0.5	100.000	10
2	Гэр бүлийн хэрэгцээ	14000000	0.5	70.000	7
3	Хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэл	16000000	0.15	24.000	2.4
4	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл	12000000	0.5	60.000	6

оОо